



ҮНДЭСНИЙ
АУДИТЫН
ГАЗАР

ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ

МОНГОЛ УЛСЫН 2019-2021 ОНЫ НЭГДСЭН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

ЗАСГИЙН ГАЗРЫН 2019-2021 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

2022 он



АГУУЛГА

Монгол Улсын 2019-2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	3
Засгийн газрын 2019-2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит	22

АУДИТЫН НЭР

МОНГОЛ УЛСЫН 2019-2021 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

Аудит хийсэн үндэслэл

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтын дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийдэг.

Аудитын зорилт

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгддэг.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000, Аудитын олон улсын стандарт, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг баримтлан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэн, Сангийн яам болон бусад холбогдох яам, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулдаг.

Хамарсан он

2019, 2020, 2021 он

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл

- Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн нийт орлого ба тусламжийн 12,040.3 тэрбум, нийт зарлага ба цэвэр зээлийн 11,661.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг аудитаар баталгаажууллаа.
- Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн дүн 9,463.8 тэрбум, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 13,904.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй болохыг аудитаар баталгаажууллаа.
- Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн дүн 12,711.4 тэрбум, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 15,630.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй болохыг аудитаар баталгаажууллаа;



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААР ОНЦОЛСОН АСУУДЛУУД

2020 он:



- Цахим шилжилтийг хурдасгах зарчмын хүрээнд “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТУГ-аас Нэгдсэн нэвтрэлтийн, Цахим төлбөрийн баримтын, Цахим тайлангийн, Татвар төлөгчийн бүртгэлийн, Бараа бүртгэлийн нэгдсэн, Төрийн үйлчилгээний төлбөрийн нэгдсэн, Төрийн албаны цалингийн нэгдсэн, Онцгой албан татварын тэмдгийн хяналтын, Санхүүгийн нэгдсэн мэдээллийн, Халамжийн нэгдсэн системүүдийг хөгжүүлж, нэвтрүүлсэн нь тодорхой үр дүнд хүрсэн байна.



- Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу төрөөс хариуцан төлөх айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан эрчим хүч, дулаан уур, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр, энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нийгмийн хариуцлагын хүрээнд 2021 оны 5 дугаар сарын байдлаар нийт 464.0 тэрбум төгрөг зарцуулснаас тайлант онд хамаарах хөнгөлөлт, чөлөөлөлт 66.9 тэрбум төгрөг байна.



- Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засгийн газрын 2020 оны 50 дугаар тогтоолоор тэтгэврийн 6.0 сая буюу түүнээс доош үнийн дүн бүхий зээлтэй нийт 228,574 иргэний 694.9 тэрбум төгрөгийг “Эрдэнэс монгол” ХХК-ийн охин компанийн эзэмшлийн Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос төрд ногдох өгөөжийг барьцаалан үнэт цаас гаргах замаар чөлөөлсөн байна.



- Сүүлийн 3 жилийн төсвийн тухай хуулиар Зоос банкны эрх хүлээн авагчаас авах авлага 25.0 тэрбум, Анод банкнаас авах авлага 10.0 тэрбум, Хадгаламж зээлийн хоршоодод мөнгөө хадгалуулсан иргэдэд учирсан хохиролд төсвөөс олгосон 20.6 тэрбум, нийт 55.6 тэрбум төгрөгийг эргэн төлүүлэхээр баталдаг боловч төлөлт хийгдээгүй байна.



- Төлбөрийн чадвар буурсан нэр бүхий 2 банканд ЭМДС, НДС-ийн нийт 161.5 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө байршуулсан нь төлбөр барагдуулах, зарлагын гүйлгээ, гэрээнд заасан хуваарийн дагуу төлөлтүүд хийгдээгүй, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байгаагаас сангийн мөнгөн хөрөнгийг үр ашигтай удирдах, хүүгийн орлого олох боломжийг бууруулж, байршуулсан мөнгөн хөрөнгөд эрсдэл үүсэж байна.



- Дампуурсан Капитал банкны эрх хүлээн авагчаас төрийн байгууллагуудын авах авлагад үл хөдлөх хөрөнгийг авах саналыг ирүүлсэн нь хөрөнгийн үнэлгээ зах зээлийн үнээс хэт өндөр байх, хөрөнгө хэрэгцээ шаардлагагүй байх, хөрөнгийг худалдан борлуулах, хадгалах, хамгаалах нэмэлт зардал гарах сөрөг үр дагавартай байна.

2021 он:

Засгийн газраас 2017 оноос өмнө гаргасан, улсын төсөвт болзошгүй өр төлбөр үүсгэх эрсдэл бүхий дараах өрийн баталгаа байна. Үүнд:



- Үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ ТӨХК-ийн агаарын хөлгийн паркийг шинэчлэн өргөжүүлэх, Олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд урт хугацаат зээл авсан “Боинг 767-300ER” агаарын хөлгийн гадаад зээлийн эргэн төлөлтийн хугацаа 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр дуусгавар болно.
- Монгол Улсын Хөгжлийн банкны 30.0 тэрбум иенийн дүн бүхий, 10 жил хүртэлх хугацаатай, жилийн 1.52 хувийн хүүтэй “Самурай” бондыг Засгийн газрын баталгаагаар арилжаалсан бөгөөд үндсэн төлбөр 2023 онд төлөгдөхөөр хүлээгдэж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ



- Алсын хараа 2050, Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн салбарын шинэчлэлтэй холбоотой ажлууд 2021 онд хэрэгжиж эхэлсэн байна.



- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны “Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулах тухай” 02 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй буюу сангийн 2021 оны орлогын 8 хувьтай тэнцэх хэмжээгээр эрсдэлийн санг байгуулаагүй байна.



- Монгол Улсын Их Хурлын 2020 оны "Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 39 дүгээр тогтоолын дагуу аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад 40.2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авах зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгөөс санхүүжүүлсэн байна.



- Салбарын шинэчлэлийн хүрээнд ЭМДС-аас гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд шилжсэнээр дараах үр дагавар үүсэж байна. Тухайлбал:
 - Гүйцэтгэлээр санхүүжилт олгосноор сангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 2.1 дахин нэмэгдэж, зардал өмнөх оноос 2.8 дахин өссөн;
 - Нэг иргэнд ногдох эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардал өмнөх оноос 1.8 дахин нэмэгдсэн нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарт бус үйлчлүүлэгчийн тоонд анхаарах эрсдэл үүссэн;
 - Төрийн болон орон нутгийн өмчит эмнэлгүүд ЭМДС-аас санхүүжилтээ бүрэн авч чадаагүйгээс эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалттай холбоотой байгууллагад төлөх өглөг 49.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 13.7 дахин өссөн;
 - Лавлагаа шатлалын эмнэлгүүдийн харилцах дансны 30.8 тэрбум төгрөгийн үлдэгдэл, төлбөртэй үйлчилгээний авлага 157.8 тэрбум төгрөгийг зарцуулах журам боловсруулаагүй, зарцуулалтад тавих хяналтгүй.



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАГЦ АРГА ХЭМЖЭЭ (5 ИХ НАЯДЫН ХӨТӨЛБӨР)

Дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед авч хэрэгжүүлэх багц арга хэмжээг УИХ-ын тогтоолоор баталсан байна. Засгийн газар тус тогтоолын хэрэгжилтийг хангаж цар тахлын эсрэг эдийн засгийн арга хэмжээг 5,091.3 тэрбум (5.1 их наяд багц) төгрөгөөр төлөвлөсөн байна.



2020 он: ТӨСВИЙН ОРЛОГОД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

- Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын эсрэг эдийн засгийн арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ААН, иргэдийн ажлын байрыг хамгаалах татварын хөнгөлөлт, чөлөөлөлт улс, орон нутаг, НДС-ийн орлогод 1,129.6 тэрбум төгрөгийн нөлөө үзүүлсэн байна.



ТӨСВИЙН ЗАРЛАГАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

- Цар тахлын эсрэг эдийн засгийн арга хэмжээнд нийт 3,272.5 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Үүнээс гадаад зээлийн эх үүсвэр 63.8 хувь буюу 2,089.1 тэрбум, улсын төсвөөс 34.3 хувь буюу 1,122.9 тэрбум төгрөгийг зарцуулсан нь нийт зардлын 98.1 хувийг эзэлж байна.



- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад гадаад зээлээс 225.9 тэрбум, улсын төсвөөс 126.6 тэрбум, орон нутгийн төсвөөс 20.6 тэрбум нийт 373.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Мөн улсын төсвийн санхүүжилтийн 88.7 хувь буюу 996.3 тэрбум төгрөг иргэдийн орлогыг хамгаалахад чиглэсэн халамжийн зардал, 11.3 хувь буюу 126.6 тэрбум төгрөгийг иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад зарцуулсан байна.



2021 он:

ТӨСВИЙН ОРЛОГОД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ



- Цар тахлын эсрэг иргэдийн ажлын байрыг хамгаалах зорилгоор нийт 359.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн нь татварын орлогыг бууруулсан боловч аж ахуйн нэгж байгууллага болон иргэдийн орлогыг хамгаалсан эерэг нөлөөг үзүүлжээ.

ТӨСВИЙН ЗАРЛАГАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ



- Цар тахлын эсрэг эдийн засгийн арга хэмжээнд нийт 4,805.1 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Үүнээс гадаад зээлийн эх үүсвэрээс 754.8 тэрбум, улсын төсвөөс 3,013.5 тэрбум, бусад эх үүсвэрээс 1,036.8 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан нь улсын төсвийн урсгал зардлын 49.3 хувийг эзэлж, төсвийн алдагдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна.

ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛЖ, ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ 10.0 (АРВАН) ИХ НАЯДЫН ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ

10 ИХ НАЯДЫН ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ



- Цар тахалтай тэмцэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, эдийн засгаа сэргээх зорилгоор “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-г Монгол Улсын Засгийн газрын 42 дугаар тогтоолоор баталсан байна.



- Засгийн газрын тус тогтоолд Иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад 23, Эдийн засгаа сэргээхэд 33, нийт 2 зорилтын хүрээнд 56 арга хэмжээний хүрээнд эдийн засгаа сэргээх арга хэмжээг 10,000.0 тэрбум (10.0 их наяд цогц) төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.



- Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө-ний хүрээнд улсын төсвөөс нийт 94.0 тэрбум, гадаадын зээл, тусламжаас 136.7 тэрбум төгрөгийг зарцуулж, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн бондоор 692.5 тэрбум, банкны эх үүсвэрээс 4,284.3 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна.



- Тайлант онд ажлын байрыг дэмжих болон хөдөө аж ахуйг дэмжих зээлийн Засгийн газрын хариуцан төлөх хүүгийн дэмжлэгт нийт 77.2 тэрбум төгрөгийг төсвөөс олгосон байна.



- Монголбанк болон банкны дотоод хяналт шалгалтаар нийт 468.6 тэрбум төгрөгийн ажлын байрыг дэмжих зээлд шалгалт хийж, зээлийн гэрээний шаардлагыг хангаагүй нийт 6.2 тэрбум төгрөгийн 66 зээлдэгчийн зээлийн хүүгийн дэмжлэгийг зогсоож, энгийн зээлийн ангилалд шилжүүлсэн байна.



- Тайлант онд Засгийн газрын 2019 оны 343, 2020 оны 15, 101, 129, 130, 138, 2021 оны 72 дугаар тогтоолоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын урамшуулалд нийт 70.0 тэрбум төгрөгийн татаас олгосон нь Засгийн газрын 42 дугаар тогтоолоор хэрэгжүүлж буй хөдөө аж ахуйг дэмжих зээлийн арга хэмжээнүүдтэй давхцсан байна.

- Эдийн засгийг идэвхжүүлж, бүтээн байгуулалтыг сэргээхэд Эрдэнэс Тавантолгой ХК-ийн бонд болон төслийн зээл, тусламжаас нийт 829.2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.



УЛЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛСАН

2019 он

- Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн төсвийн тухай хуулийг хэлэлцэж, батлахдаа төсвийн тогтвортой байдлыг хангах хуулийн шаардлагыг баримталж, өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн, өөрчлөлт хийхгүй байх.
- Засгийн газар ба орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын төсвийн эрх мэдлийн хуваарилалтыг нэгдмэл зохицуулалтад оруулж эрх зүйн орчныг сайжруулах.
- ТЕЗ-д өгсөн аудитын зөвлөмжийн хэрэгжилт, дүнг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороогоор хэлэлцүүлэн төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой шийдвэр гаргуулах саналыг уламжилж байна.

2020 он

- Засгийн газрын амлалтын шинж чанартай эдийн засгийн арга хэмжээнүүдийн санхүүжүүлэх эх үүсвэр, зарцуулалтыг төсвийн бүрэлдэхүүнд оруулан Төсвийн тухай хуулиар баталж байх;
- Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, тогтолцоог боловсронгуй болгох зэрэг арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг толилуулж байна.

2021 он

- Төсвийн төслийг боловсруулах үйл явцад иргэд, олон нийтийн оролцоог хангах, төсвийн ил тод байдлыг дээшлүүлэх талаар Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах;
- Мөн тухайн жилийн төсвийн хөрөнгийн зарцуулалтын хүрсэн үр дүн, Улсын Их Хурлаас баталсан төсвийг Монгол улсын тогтвортой хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогын зорилтуудыг хангахад чиглүүлсэн тухай дэлгэрэнгүй танилцуулга"-ыг Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүнд тусгах талаар Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах;
- Улсын төсвөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй нийцүүлэн баталж, салбарын түвшинд төлөвлөөгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хуульд тусгаж буй зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэлээр хариуцлагын болон үр дүнтэй хяналтын тогтолцоог бүрэн бүрдүүлэх;
- Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний хэлтэс, дотоод аудитын албаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар сүүлийн 11 жилд Улсын Их Хуралд толилуулсан асуудалд шинжилгээ хийлгэж, үр дүнг Төсвийн байнгын хороонд танилцуулах чиглэлээр үүрэг өгч ажиллах;
- Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн үйл ажиллагаанд барилгын материалын хомсдол, үнийн өөрчлөлт, тээвэрлэлтийн саатал гарч төслүүд бүрэн дуусахгүй, хэрэгжилт удаашрах нөхцөл байдал үүссэн зэрэг нь цаашид энэ тохиолдолд асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаарх эрх зүйн орчныг тодорхой болгох шаардлага байгааг толилуулж байна.



АУДИТЫН ДҮГНЭЛТҮҮД:

2019 он	2020 он	2021 он
1. Тайлант оны төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 756.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь ДНБ-ий 2.0 хувьтай тэнцүү, батлагдсан үзүүлэлтээс 3.4 нэгж хувиар буурч, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна. 2. Тайлант онд “Цахим, ил тод, үр ашигтай” төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх хүрээнд 7 бодлогын зорилт дэвшүүлснээс 5 зорилтыг хангаж, 2 зорилт дунд хугацаанд хүлээгдэх үр дүнтэй байна. 3. Сүүлийн 3 жилийн байдлаар орлогын өсөлтийн хурд саарсан, зарлагын өсөлтийн хурд идэвхжих хандлагатай байна. 4. Макро түвшний судалгаа, зах зээлийн гадаад, дотоод хүчин зүйлсийн үндэслэлийг бодитой тооцоолж, тусгаагүйгээс батлагдсан Төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдэд өөрчлөлт оруулсан, Төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтийг төсвийн төлөвлөлтөд 3, төсвийн гүйцэтгэлд 1 үзүүлэлтээр тус тус хангаагүй байна. 5. Татварын бүртгэл, мэдээллийн системд хамрагдалт сайжирсан, уул уурхайн голлох нэр төрлийн зарим эрдэс бүтээгдэхүүний биет хэмжээ, үнэ өмнөх оноос өссөн, тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээний үр дүнд экспорт, гадаад худалдааны эргэлт нэмэгдсэн зэрэг шалтгааны улмаас төсвийн татварын	1. Тайлант оны төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 4,440.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 12.0 хувьтай тэнцэж, УИХ-аас тогтоосон хэмжээнээс хэтрээгүй байна. 2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын Цар тахалтай холбоотойгоор төсөвт тодотгол хийхдээ нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дээд хэмжээг 10.4 хувиар нэмэгдүүлж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 12.5 хувиар бууруулан баталж орлого, зарлагын харьцааг хангаагүй байна. 3. Коронавируст халдвар (Ковид-19) Цар тахлын эсрэг эдийн засгийн “5.1 их наяд багц” арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажлын байрыг хадгалах татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд зориулсан 1,193.0 тэрбум төгрөг нь нэгдсэн төсвийн нийт орлогыг 13.0 хувиар бууруулж, улсын төсөв болон гадаад зээл, тусламжаас 3,272.5 тэрбум төгрөгийг зарцуулсан нь нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 23.5 хувийг, ДНБ-ий 8.8 хувийг тус тус эзэлж байна. 4. ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр 2017 оноос эхлэн хэрэгжиж 2,384.3 сая ам.долларын санхүүжилтийн эрх олгогдсоноос 1,329.2 сая ам.долларын дэмжлэг авч, 1,055.1 сая ам.долларын эх үүсвэрийг ашиглаагүй байна. 5. Монгол Улсын 2020 оны	1. Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд арилжааны банкаар дамжуулан олгосон хөнгөлөлттэй зээл болох 4,284.3 тэрбум төгрөгийг 62.7 мянган зээлдэгчид олгосон нь 144.6 мянган ажлын байрыг хадгалж, зээл олголт нэмэгдэж, эдийн засаг эргэлтэд орох нөхцөл бүрдсэн байна. 2. Цар тахлын эсрэг эдийн засгийг сэргээх арга хэмжээний хүрээнд ажлын байрыг хадгалахад чиглэсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт төсвийн нийт орлогыг 2.5 хувь буюу 359.6 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлж, улсын төсөв болон гадаад зээл, тусламжаас 4,805.1 тэрбум төгрөгийг зарцуулсан нь нэгдсэн төсвийн нийт зарлагын 30.7 хувийг, ДНБ-ий 11.1 хувийг эзэлж байна. 3. Төсөвт тодотгол хийхдээ нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 2.2 хувиар, нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээг 12.9 хувиар нэмэгдүүлж баталсан нь орлого, зарлагын зохистой харьцааг хангахгүй байна. 4. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүйгээс аудитаар 11.1 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн нь бүх шатны төсөв захирагчдын төсвийн сахилга хариуцлага, хяналтын тогтолцоог



- орлого төлөвлөснөөс давж биелсэн байна.
6. Өрийн өнөөгийн үнэ цэнэ болон ДНБ-ний харьцаа 55.6 болж зорилтот түвшнээс 0.3 хувиар хэтэрсэн ч Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн шаардлагыг хангаж байна.
 7. Орон нутгийн ИТХ өмнөх оны мөнгөн хөрөнгийн 256.1 тэрбум төгрөгийн үлдэгдлээр батлагдсан төсвийг нэмэгдүүлсэн нь нэгдсэн төсвийн алдагдлыг өсгөсөн байна.
 8. ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх төлөвлөлт, гүйцэтгэл нь шийдвэр гаргалтад ашиглах ач холбогдол багатай, үр дүнгийн шалгуур үзүүлэлт тохиромжгүй, зарим хүрэх үр дүнгийн хэрэгжих боломжтой хугацааг үндэслэлтэй тооцоолоогүй, өртөг тооцоололт хангалтгүй байна.
 9. Засгийн газарт 2021-2024 онд төлөгдөх 2.9 тэрбум ам.долларын гадаад бондын өрийг барагдуулах үүрэг хүлээгдэж байна.
- нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 10,444.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 438.7 тэрбум төгрөгөөр дутуу биелэлттэй байгаа нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт өмнөх оноос 73.6 хувиар нэмэгдсэн, гадаад худалдааны эргэлт саарсан, үйл ажиллагаа явуулаагүй аж ахуйн нэгжийн тоо өссөнтэй холбоотой байна.
6. Засгийн газрын өр хуулиар тогтоосон хэмжээнээс хэтрээгүй боловч өмнөх оноос 15.3 хувиар нэмэгдсэн, гадаад зээлийн ашиглалт 3,368.4 тэрбум төгрөгөөс төсвийн дутагдлыг санхүүжүүлэхэд зориулж авсан хөтөлбөрийн зээл 1,978.0 тэрбум төгрөг буюу 58.7 хувийг эзэлж байна.
 7. Гадаад зээл, үнэт цаасны ханшийн тэгшитгэлийн зөрүүнээс үүссэн алдагдал сүүлийн 5 жилд дунджаар 1,137.6 тэрбум, тайлант онд 1,355.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь ирээдүйд төлөх өрийн ачааллыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.
 8. Төсвийн төсөл бэлтгэх удирдамжид хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулах нарийвчилсан зааврыг тусгаагүйгээс зарим хөтөлбөрийн зорилтот түвшин, шалгуур үзүүлэлт оновчтой бус байна.
 9. Цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн эдийн засгийг дэмжих, иргэдийн орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах зарим арга хэмжээ төсөвт тусгагдаж, тайлагнагдахгүй байгаа нь Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудтай нийцэхгүй байна.
- сайжруулах шаардлагатай байна.
5. Тайлант оны төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 2,919.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 6.8 хувьтай тэнцэж, УИХ-аас тогтоосон хэмжээнээс хэтрээгүй байна.
 6. Өрийн зохицуулалт хийснээр Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл өмнөх оноос 342.0 тэрбум төгрөгөөр буурч, багцын жигнэсэн дундаж хүүг 5.58 хувьд хүргэж, эргэн төлөлтийн дундаж хугацаа 4.9 жилээр уртассан байна.
 7. Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 876.5 тэрбум төгрөг, үүний 93.7 хувийг эзэлж буй Монгол Улсын Хөгжлийн банкны 2023 онд төлөх 30 тэрбум иенийн “Самурай” бонд, 2031 онд төлөх “Эрдэнэс Монгол” ХХК-ийн техникийн туслалцааны зээлүүд нь төсөвт болзошгүй өр төлбөр үүсгэх эрсдэлтэй байна.
 8. Засгийн газрын “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-д тусгасан 56 арга хэмжээний хэрэгжилтийн явцад үнэлгээ хийгээгүй байна.
 9. Хөдөө аж ахуйг дэмжих арга хэмжээнд 494.2 тэрбум төгрөгийн зээл, салбарын урамшуулалд нийт 70.0 тэрбум төгрөгийн татаас олгосон нь тус салбарт хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг нэгтгэх, нэгдсэн бодлогоор хангах, давхцалыг арилгах, үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
 10. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж гүйцэтгэлээр санхүүжилт олгосноор Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлыг санхүүжүүлэх эх



- үүсвэр 2.1 дахин нэмэгдэж, зардал өмнөх оноос 2.8 дахин өссөнөөр төсвийн тэнцлийн алдагдал сангийн нийт орлогын 19.8 хувийг эзэлж, сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс алдагдлыг санхүүжүүлсэн байна.
11. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд шилжсэн байгууллагуудын төсвийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагналтай холбоотой нэгдсэн журам, заавар, аргачлалыг батлуулаагүй, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.
12. Төсвийн ил тод байдал дээшилж буй боловч төсвийн төслийг боловсруулах үйл явцад иргэд, олон нийт оролцох боломжийг бүрдүүлэх, төсвийн гүйцэтгэлийн тайлагналыг бодлогын зорилтын биелэлттэй уялдуулах шаардлагатай байна.
13. Нэмэлт төсвийн орлого 1,696.5 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 84.0 хувиар, урсгал зарлага 1,666.5 тэрбум төгрөг буюу 77.4 хувиар өссөнөөр нэгдсэн төсвийн зарлагын 10.0 орчим хувьтай тэнцэж, төсвийн гадуурх нэмэлт орлого зарлага жил бүр өсөх хандлагатай байгаа нь төсвийн хяналт сулрах эрсдэлтэй байна.
14. Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-6.1.4-т заасан тусгай шаардлагыг тус тус хангаж байна.
15. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг нэгдсэн бодлогоор төлөвлөх эрх зүйн орчин бүрдсэн ч хууль, журмын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй, хөрөнгө оруулалтын оролцогч талуудын хамтын ажиллагаа уялдаагүйгээс төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд ахиц дэвшил гарахгүй байна. Тухайлбал,
- УИХ-ын 2020 оны “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгасан 6 төсөл, арга хэмжээний 79.2 тэрбум төгрөгийг огт тусгаагүй, 4 төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг 74.4 тэрбум төгрөгөөр бууруулж баталсан нь хөгжлийн бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй;
 - Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг УИХ-аас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-т заасан хугацаанд батлаагүй, 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр баталсан нь төсвийн төлөвлөлтийн цаглабарын хувьд ТЕЗ-д Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.5-д заасан төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан байх шаардлагыг хангах боломжгүйд хүргэжээ.
16. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтад Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн саналд тусаагүй, хэрэгцээ, шаардлагын үндэслэл тооцоолол бүрэн бус барилга, байгууламж, их засвар, тоног төхөөрөмж худалдан авах, ТЭЗҮ боловсруулах 110 ажлыг баталсан нь салбарын бодлого алдагдах сөрөг нөлөөтэй байна.
17. Сангийн яамнаас 2019 оноос эхлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагаанд төлөвлөлтийн аргачлал, журам болон цахим систем /www.publicinvestment.gov.mn/-ийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн нь төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага, үр ашгийг сайжруулахад томоохон ахиц, дэвшил гарсан ч цаашид хэрэгжилтийг жигдрүүлэх шаардлагатай байна.
18. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хүн ам зүй, газар зүйн байршил, бусад хүчин зүйлстэй бүрэн уялдуулж төлөвлөөгүйгээс нийгмийн тогтвортой хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.
19. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулж төлөвлөөгүй, төрийн өмчид хамаарахгүй, хөрөнгийн бүртгэлд бүртгэх боломжгүй урсгал зардлын шинжтэй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөн хэрэгжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр нөлөө, тэгш хүртээмжийг бууруулж байна.
20. ТЕЗ-д улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжих барилга,



2021 он

- байгууламж, их засварын 345 төсөл, арга хэмжээ хэрэгжихээс 325 буюу 94.2 хувьд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг 4 дүгээр сараас хойших хугацаанд буюу барилгын улирал эхэлснээс хойш зохион байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.8-д “барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх” гэж заасныг зөрчиж, төсөл, арга хэмжээ тайлант онд бүрэн хэрэгжихгүй байхад нөлөөлжээ.
21. Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад ТБОНӨХБАҮХАТХ болон түүнд нийцүүлэн гаргасан журмуудын хэрэгжилт хангалтгүй, хяналтын тогтолцоо сул байгаагаас тендерийн хэмнэлтээр гэрээний үнийн дүнгийн 15 хувиас хэтэрсэн дүнгээр нэмэлт гэрээ байгуулах, төсөвт тусгаагүй нэмэлт ажил гүйцэтгүүлэхэд зарцуулж байгаа нь худалдан авах ажиллагаанд эрх тэгш, шударгаар өрсөлдөх, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах сонирхлыг бууруулж байна.
 22. Барилга, байгууламжийн зураг төсөл, төсөв боловсруулах, магадлал хийх, худалдан авах ажиллагаа зохион байгуулах, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хариуцлагын тогтолцоог сайжруулснаар зардлыг багасгах, үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой байна.
 23. Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулахаас эхлэн магадлал хийх, тухайн төсөл, арга хэмжээ дуусах хүртэл нэгдмэл байдлаар хяналт тавих тогтолцоог цогцоор нь оновчтой болгох, түүнд хамаарах байгууллагуудын хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.
 24. Магадлалаар баталгаажаагүй төсөвт өртгөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан нь хуулийн шаардлага хангаагүй, улмаар төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.
 25. Барилга угсралтын ажлын явц, гүйцэтгэлд тавих мэргэжлийн байгууллагын хяналт хангалтгүйгээс барилга угсралтын ажлыг гүйцэтгэхдээ материал сольж чанар байдлыг доройтуулж байна.
 26. Урсгал зардлаас хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл, арга хэмжээнд санхүүжилт хуваарилж, түүний худалдан авах ажиллагаа зохион байгуулж, санхүүжүүлсэн байна.
 27. Хөрөнгө оруулалтын санхүүжилтээр худалдан авсан техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилгын ашиглалт хангалтгүй байна.
 28. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлбар зэрэг мэдээллийг давхардсан тоогоор 1,531 байгууллага ил тод мэдээлээгүй зөрчилтэй байна.
 29. Аудитад хамруулсан 5,605 төсөвт байгууллага, ТБОНӨҮГ-ууд нь 2021 оны байдлаар нийт 472.1 тэрбум төгрөгийн мөнгөн дүн бүхий 13,173 удаагийн орлого, зарлагын гүйлгээг ил тод мэдээлээгүй, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасныг зөрчсөн байна.
 30. Төсөвт байгууллага, ТБОНӨҮГ-ууд 2021 онд өр, авлага үүсгэсэн нийт шийдвэрийн 10.6 хувийг, тендер, худалдан авалтын үйл ажиллагааны мэдээллийн 6.2 хувийг ил тод мэдээлээгүй байна.
 31. Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны системд мэдээллийг гараар шивж оруулдаг, механик ажиллагаатайгаас төсвийн орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, тендер худалдан авалт зэрэг олон удаагийн давтамжтай хийгддэг мэдээллийг ил тод бүрэн байршуулдаггүй зөрчил гарах голлох шалтгаан болж байна.
 32. Засгийн газар болон, Сангийн яаманд байгуулагдсан Шилэн дансны тухай хууль болон “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг шинэчлэх, Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөгжүүлэлт хийх чиг үүрэг бүхий Ажлын хэсгүүдийн ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ӨГСӨН АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

2019 он	2020 он	2021 он
1. Үр дүнд чиглэсэн хөтөлбөрт төсөвлөлтийг хэрэгжүүлэхийн тулд улсын салбарын түвшинд хөтөлбөрийн хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн иж бүрэн систем бий болгож ажиллах. 2. Төсвийн бодлогын хүрээнд тайлант онд дэвшүүлсэн зорилтоо бүрэн хэрэгжүүлэхэд анхаарал хандуулж, үр дүнг тооцож ажиллах. 3. Төсөв боловсруулах, өргөн мэдүүлэхдээ эдийн засгийн өсөлттэй уялдуулан хүлээгдэж буй өрийг барагдуулах ажлыг төсөвт хүндрэл учруулахгүйгээр зохион байгуулах.	1. Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэх, үе шаттайгаар хэрэгжилтийг хангаж, тайлагнах; 2. Засгийн газраас хэрэгжүүлэх аливаа хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн шалгуурыг хэмжих нэгдсэн систем бий болгох ажлыг эрчимжүүлэх, зардлын үр ашгийг хянах тогтолцоог бүрдүүлэх, төсөв захирагчдын төсвийн сахилга батыг сайжруулах; 3. Халамжийн хэт тэлэх бодлогыг хумих, төсвийн санхүүжилтээр ажлын байрыг бий болгох, эдийн засгийг сэргээх чиглэлд үр ашигтай зарцуулж, тайлагнаж байх; 4. Засгийн газраас өрийн зохицуулалтын шинэчлэл хийх, бага хүүтэй, ханшийн эрсдэлгүй дотоод эх үүсвэрүүдийг ашиглах боломжийг судалж хэрэгжүүлэх; 5. Дотоодын зах зээл дээр хүүгийн түвшин сүүлийн жилүүдэд тогтвортой буурах хандлагатай байгаа тул дотоодод засгийн газрын бонд гаргах замаар төсөвт ирэх ханшийн эрсдэлийг бууруулах, дотоодын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг нэмэгдүүлэх;	1. Эрүүл мэндийг хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн бүтээн байгуулалтын төслүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, хэрэгжилтийн үр дүнг тооцож, үнэлэх; 2. Засгийн газрын хэрэгжүүлж буй зарим хөнгөлөлтэй зээл, урамшууллын арга хэмжээнүүдийн давхцалыг арилгах, нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх; 3. Гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд шилжсэн Эрүүл мэндийн байгууллагуудын хүрэх үр дүнг тодорхойлох аргачлал, шалгуур үзүүлэлтийг тогтолцооны шинэчлэлтэй уялдуулан боловсруулах, хэрэгжилтийг хангах; 4. Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох тусламж, үйлчилгээний тариф, төлбөрийн хэмжээг бодитой тогтоох, Эрүүл мэндийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах журам, зааврыг боловсруулж, эрх зүйн орчныг сайжруулах; 5. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын үйл ажиллагаанд сайн засаглалын тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээг авч, төсвийн төлөвлөлтөд улсын дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төсөв хоорондын уялдааг хангуулах; 6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсвийн төслийг боловсруулахад ил тод, хариуцлагатай байх зарчмыг мөрдөж ажиллахад УИХ-тай хамтарч ажиллах;



2021 он

7. Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгийг зөрчсөн төрийн албан хаагчдад уг хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага тооцох;
8. Шилэн дансны тухай хуулийг бусад хууль тогтоомжтой уялдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн ажлыг эрчимжүүлж, төрийн санхүү, төсвийн үйл ажиллагааны ил тод байдлыг бүрэн хангуулах;
9. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байгууллага, албан тушаалтанд хяналт тавих, хариуцлага тооцох зохицуулалтыг байгууллага, албан тушаалтны төрөл, ангилалд тохируулан оновчтой болгон хууль тогтоомжид тодорхой тусгах;



САНГИЙН САЙДАД ӨГСӨН АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

2019 он

1. Сүүлийн 3 жилийн байдлаар нэгдсэн төсвийн орлогын өсөлтийн хурд саарсан, зарлагын өсөлтийн хурд идэвхжих хандлагатай байгааг анхаарч, төсвийн тогтвортой байдлыг хангаж ажиллах.
2. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг тооцох аргачлалд орон нутгийн төсвийн зарлагын дээд хязгаарыг хэрхэн тооцож хянах талаар тодорхой тусгаж, дээд шатны төсөвт тодотгол хийгээгүй үед орон нутгийн төсөвт өөрчлөлт оруулахыг зогсоох.

2020 он

1. Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуулийг боловсруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгах эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг бодитой тооцож, төсвийн төлөвлөлт, тодотголд тууштай баримтлах, орлого, зарлагын өсөлтийг уялдуулах;
2. Өрийг дахин санхүүжүүлэх, нийгэм эдийн засагт зайлшгүй шаардлагатай төслийг санхүүжүүлэхээс бусад зорилгоор гадаад өрийг нэмэгдүүлэхгүй байх;
3. ТЕЗ-дын харьяа байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөх, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, орлогын төлөвлөгөөгүй байгууллагуудад зарцуулах эрх олгохгүй байх, давсан орлогыг зарцуулах эрхийг жилд 2 удаа нээж санхүүжүүлэхээр тусгасан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

2021 он

1. Гадаад зээлийн хөрөнгийг хөгжлийн бодлого, түүний зорилттой уялдуулан эдийн засаг нийгмийн үр ашигтай төсөлд зарцуулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх, зөвхөн хуулийн шаардлага хангасан төслийг санхүүжүүлэх;
2. Засгийн газрын өрийн баталгаа гаргуулсан хуулийн этгээдүүдийн төлбөрийн чадварыг тодорхойлон эрсдэлийн үнэлгээ хийж, болзошгүй өр төлбөр үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах;
3. Дунд хугацаанд төлөхөөр хүлээгдэж буй гадаад үнэт цаасны төлбөрийг төсөвт дарамт учруулахгүйгээр төлж барагдуулах бодлогыг үргэлжлүүлэн төсвийг алдагдалгүй төлөвлөх зарчим баримтлах;
4. Төрийн санхүү, төсвийн үйл ажиллагааг зохицуулсан холбогдох дүрэм журамд өөрчлөлт оруулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;
5. Төсвийн орлогыг нэмэгдүүлж, зардал бууруулах, нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийн



2021 он

- зарцуулалтад хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангаж, үр дүнг үнэлж ирүүлэх;
- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилтийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн жил дамжуулан Төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах, банкны баталгааг үндэслэн олгох зохицуулалтыг хууль, эрх зүйн баримт бичигт тусгах, төсвийн сахилга батыг хангуулах;
 - Төсвийн нийт хөрөнгө оруулалт буюу улсын төсөв, орон нутаг, гадаад зээл тусламж, концессын эх үүсвэрийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын хүрээнд төлөвлөж, хяналт зохицуулалт, нэгдсэн системийг бий болгох;
 - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын үйл ажиллагаанд Сангийн яамны оролцоог хангах эрх зүйн орчин бүрдүүлэх;
 - Төсвийн үйл ажиллагаанд ашигладаг системүүдтэй мэдээлэл солилцох шийдлийг оновчтой болгож, Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулах үйл ажиллагааг автоматжуулах.



**ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙДАД ӨГСӨН
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

2021 он

- Гадаад зээлийн хөрөнгийг хөгжлийн бодлого, түүний зорилттой уялдуулан эдийн засаг нийгмийн үр ашигтай төсөлд зарцуулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх, зөвхөн хуулийн шаардлага хангасан төслийг санхүүжүүлэх;



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДАД
ӨГСӨН АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

2021 он

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хэрэгжих төсөл, арга хэмжээг хэрэгцээ, шаардлага, үр ашгаар нь эрэмбэлэн төсвийн хязгаарт багтсан төсвийн саналыг хүргүүлж, төсвийн төлөвлөлтөд хууль, эрх зүйн орчныг чанд мөрдөж ажиллах;
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу төсөвт өртгийг тойм дүнгээр баталж хэрэгжүүлсэн, газрын асуудал шийдэгдээгүй, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсвийг батлуулаагүй, ажил гүйцэтгэх гэрээний дүнгээс магадлалаар баталгаажсан төсвийн дүн бага байгаа зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт болон захиалагчийн хяналтыг чангатгаж, холбогдох зохицуулалтыг хийх;
- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд зохиогчийн болон захиалагчийн хяналт үр дүнтэй хэрэгжээгүйгээс барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүйд хүрч хөрөнгийн ашиглалт, чанарыг бууруулж байгаад анхаарч, гүйцэтгэгч, хяналт хэрэгжүүлэгч байгууллагатай чанарын үр дүнг тооцож ажиллах;
- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж байнгын ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээний үр нөлөөг тооцож, тухайн жилийн бодлогын зорилтот түвшинд хүрсэн эсэх талаар дүгнэлт гаргадаг байх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний гэрээний удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх, гэрээний үүрэг, хариуцлагыг тооцдог, мэргэжлийн түвшинд үнэлж дүгнэдэг байх.




ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3-д заасан байгууллагын төрлөөр аудитад хамруулсан 6003 байгууллагыг ангилан хүснэгт 1-д харуулбал:

Аудитад хамруулсан байгууллагын тоо

Байгууллагын төрөл

Төсөвт байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой ХК, ХХК



Төрийн санхүү, төсвийн үйл ажиллагаатай холбоотой хуульд заасан мэдээллээ Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд дутуу мэдээлсэн, хуулийн хугацаа хоцроосон, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

2020 он



21 албан тушаалтанд хариуцлага тооцуулах



1081 байгууллагад зөрчил арилгуулах

2021 он



110 албан тушаалтанд хариуцлага тооцуулах



